## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Суралцагчийн өмнө нь судалсан мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийг хүлээн зөвшөөрөх нөхцөлийг тодорхойлоход энэхүү журмын зорилго оршино.

1.2 Суралцагчийн өмнө нь амжилттай судалсан, тодорхой түвшний суралцахуйн үр дүнг эзэмшсэн хичээл, түүнтэй адилтгах сургалт /цаашид “хичээл” гэнэ/, түүний үнэлгээг ОТИС-д хэрэгжиж буй хичээлийн агуулга, багц цаг, үнэлгээтэй дүйцүүлэн тооцоход холбогдох харилцааг зохицуулахад энэхүү журмыг /цаашид “журам” гэнэ/мөрдөнө.

1.3 ОТИС-ийн боловсролын ижил түвшний хөтөлбөрт шилжин суралцах, өмнө нь дээд /дипломын болон бакалавр, магистрын/ боловсрол эзэмшсэн төгсөгч эсхүл олон улсын хөтөлбөрөөр сургалт эрхэлдэг ахлах сургууль төгсөгч ОТИС-д шинээр элсэн суралцах, ОТИС-тай байгуулсан гэрээний дагуу бусад дээд боловсролын сургалтын байгууллагын зэргийн болон зэргийн бус хөтөлбөрт суралцаад буцаж ирэх, хичээл солилцооны гэрээний дагуу дотоодын их дээд сургуульд хичээл судлах, хэд хэдэн хөтөлбөрт зэрэгцэн суралцах, сургуулиас чөлөөлөгдсөн суралцагч ОТИС-д эргэн суралцах, ОТИС-ийн хөтөлбөрийн онцлогоос хамааран хичээл дүйцүүлэх тохиолдолд энэхүү журмыг баримтална.

1.4 Суралцагч гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах эсхүл гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагаас ОТИС-д суралцах үед дүнгийн системийг хөрвүүлэх, ОТИС-ийн багц цаг болон тухайн сургуулийн багц цагийн харьцааг тодорхойлоход энэхүү журамд тусгагдсан дүн болон багц цаг хөрвүүлэх аргачлалыг ашиглана.

**Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт**

2.1 Хичээл дүйцүүлэх: Нэг сургалтын байгууллагад судалсан хичээлийн суралцахуйн үр дүн, багц цаг, үнэлгээг нөгөө сургуулийн харгалзах хичээлийн суралцахуйн үр дүн, багц цаг, үнэлгээг нөгөө сургуулийн харгалзах хичээлийн суралцахуйн үр дүн, багц цагийн агууламж, стандарт болон үнэлгээний системээс хамааруулан дүйцүүлэн тооцох үйл ажиллагааг хэлнэ.

2.2 Багц цаг хөрвүүлэх: Нэг сургалтын байгууллагад судалсан хичээлд ногдуулсан багц цагийн ачааллаас хамааруулан нөгөөд сургалтын ачааллаас хамааруулан хөрвүүлэн тооцох үйл ажиллагааг хэлнэ.

2.3 Дүн дүйцүүлэх: Нэг сургалтын байгууллагад суралцаж үнэлэгдсэн хичээлийн дүнг нөгөөд, үнэлгээний системээс хамааруулан дүйцүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

2.4 Зэргийн бус сургалт: Үндсэн хөтөлбөрт элсэх зорилго бүхий бэлтгэл хөтөлбөр /монгол хэлний бэлтгэл/ болон үндсэн хөтөлбөрт суралцаж байх хугацаандаа өөрийн мэргэжлийн дагуу оюутан солилцоо, мэргэших дадлага /интерншип/, зуны болон богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдахыг хэлнэ.

2.5 Хамтын ажиллагааны гэрээ: Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагууд сургалтын үйл ажиллагаатай холбогдуулан оюутан солилцооны, зэргийн болон зэргийн бус хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай харилцан тохиролцож байгуулсан баримт бичиг.

2.6 Хичээл солилцооны гэрээ: Хамтын ажиллагааны гэрээ бүхий дотоодын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагуудын хөтөлбөр хариуцсан багууд

хөтөлбөр/хичээлийн суралцахуйн үр дүн, үнэлгээг харилцан хүлээн зөвшөөрч, сургалтын үйл ажиллагааг аль нэг сургуульдаа судлах боломжийг олгосон, хичээлийн жагсаалт бүхий баримт бичиг.

2.7 Суралцах гэрээ: Хамтын ажиллагааны гэрээнд заагдсан нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж ирэх тухай сургуулийн удирдлага, мэргэжлийн тэнхим болон суралцагчийн хооронд байгуулсан гуравласан гэрээ.

2.8 Дэлхийн шилдэг их сургуулийн жагсаалт: Дэлхийн их дээд сургууль, коллежуудын эрэмбэ тогтоодог “Times Higher Education” байгууллагаас гаргасан “Impact Ranking” шалгуурын сүүлчийн оны эрэмбийн жагсаалт

**Гурав. Хичээл дүйцүүлэхэд баримтлах ерөнхий шаардлага**

3.1 Хичээл дүйцүүлэх үйл ажиллагаа нь албан ёсны дүнгийн тодорхойлолт болон тухайн хичээлийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд үндэслэх ба дараах шаардлагуудыг хангасан тохиолдолд дүйцүүлэх боломж нээгдэнэ. Үүнд:

3.1.1 Агуулга болон суралцахуйн үр дүнгийн 80-аас багагүй хувийн давхцалтай байх;

3.1.2 Дүйцэх хичээл нь өмнөх залгамж холбоогүй, эсвэл өмнөх залгамж холбооны хичээлийг амжилттай судалсан байх;

3.1.3 Дүйцүүлэх хичээл нь ОТИС-ийн дүйцэх хичээлийн багц цагийн хэмжээнээс 0,5-аас ихгүй багц цагийн зөрүүтэй байх;

3.1.4 Ижил түвшний хөтөлбөрүүдэд тусгагдсан байх;

3.1.5 Үнэлгээ нь тодорхой буюу дүнд хувиргах боломжтой ("тооцов" гэх мэт хувиргах боломжгүйгээр тодорхойлогдоогүй) байх;

3.1.6 Цааш үргэлжлүүлэн суралцахад бэрхшээл учруулахааргүй байх;

3.1.7 Сургууль хооронд шилжин суралцагчийн хичээл дүйцүүлэхдээ ижил түвшний хөтөлбөрүүдэд тусгагдсан, дүйцэх хөтөлбөрийн Ерөнхий суурийн болон Мэргэжлийн суурийн багцад тусгагдсан хичээлүүдээс дүйцүүлнэ.

3.2 Хөтөлбөр хооронд шилжин суралцах

3.2.1 Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжин суралцах үед журмын 3.1-д заасан шаардлагыг хангасан байх ба дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагын хувьд БМИҮЗ-өөр магадлан итгэмжлэгдсэн сургуулийн хичээлийг дүйцүүлнэ

3.2.2 Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжин суралцагчийн өмнө нь судалсан хичээлүүдээс бакалаврын өдрийн хөтөлбөрт 45 хүртэл, магистрын хөтөлбөрт 6 хүртэл, докторын хөтөлбөрт 9 хүртэл багц цагийн хичээлийг дүйцүүлэн тооцож болно.

3.2.3 Дэлхийн шилдэг 500-д эрэмбэлэгдсэн гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжин суралцах тохиолдолд журмын 3.1.7-д зээсэн багцын хязгаарлалтыг мөрдөхгүй бөгөөд бакалаврын өдрийн хөтөлбөрт 60 хүртэл, магистрын хөтөлбөрт 9 хүртэл, докторын хөтөлбөрт 15 хүртэл багц цагийн хичээлийг дүйцүүлэн тооцож болно.

3.2.4 Бусад ДБСБ-аас ОТИС-ийн цагийн хөтөлбөрт шилжин суралцахад мэргэжлийн сууриин 30 хүртэлх багц цагийн хичээлийг дүйцүүлнэ.

3.2.5 Бусад ДБСБ-аас шилжин суралцагчийн хичээлийг дүйцүүлэхдээ хөтөлбөрийн онцлогоос хамаарч 3.2.2-3.2.3-т заасан хязгаарлалтыг мэргэжлийн тэнхимийн шийдвэрээр бууруулж болно.

3.2.6 ОТИС-ийн хөтөлбөр хооронд шилжих бол журмын 3.1.1-3.1.5-д заасан шаардлагыг хангасан хичээлүүдийг дүйцүүлж болно.

3.3 Хичээл солилцон суралцах

3.3.1 ОТИС-тай байгуулсан гэрээний дагуу дотоодын ДБСБ-д судалсан хичээлийг шууд дүйцүүлэн тооцно.

3.4 Хамтарсан хөтөлбөрөөр суралцах

3.4.1 ОТИС нь гадаадын их, дээд сургуультай хамтарсан хөтөлбөрийн дагуу суралцсан суралцагчийн багц цагийг гэрээнд хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд заасны дагуу тооцно.

3.5 Ижил түвшинд шинээр элсэн суралцах

3.5.1 ОТИС-ийн төгсөгч нь ижил түвшний өөр хөтөлбөрт элсэх суралцах бол өмнөх хөтөлбөрийн хичээлээс журмын 3.1.1-3.1.5-д заасан хичээлийг дүйцүүлж болно.

3.5.2.Бусад ДБСБ-ын төгсөгч ОТИС-ийн ижил түвшний өөр хөтөлбөрт элсэх суралцах бол журмын 3.1.1-3.1.5-д заасан хичээлийг дүйцүүлж болно

3.6 Эргэн суралцах

3.6.1 Өмнө нь ОТИС-д суралцаж байсан /ректорын тушаалаар чөлөөлөгдсөн/ суралцагч нь эргэн суралцах тохиолдолд бүтцийн сургууль, мэргэжлийн тэнхимийн хичээл дүйцүүлэх тухай саналыг харгалзан ерөнхий сууриин, мэргэжлийн сууриин, мэргэжлийн хичээлүүдийг дүйцүүлж болно.

3.6.2 Бусад ДБСБ-д суралцаж байсан суралцагч ОТИС-д суралцагч элсүүлэх журмын дагуу элсэн суралцах тохиолдолд өмнө нь судалсан хичээлийг дүйцүүлэхгүй.

3.7 Олон улсын шалгалтад авсан үнэлгээг дүйцүүлэх

3.7.1 Монгол Улсад албан ёсоор Кембриджийн болон олон улсын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй дунд сургууль эсвэл гадаадын ижил түвшний сургууль судалж олон улсын А, О түвшний шалгалтад С ба түүнээс дээш үнэлгээ авсан эсвэл AS, AB, AP, IGCSE түвшний шалгалтад А үнэлгээ авсан бол бакалаврын хөтөлбөрийн Ерөнхий сууриин харгалзах хичээлүүдтэй Хавсралтын Хүснэгт 2-т заасан болон ижил чиглэлийн дагуу дүйцүүлэн тооцож болно.

3.7.3 Шалгалтын агуулгаас хамаарч А, О түвшний шалгалтын хувьд 6 хүртэлх, бусад түвшний шалгалтын хувьд 3 хүртэлх багц цагийг дүйцүүлж болно.

3.7.4 Дүйцүүлэхэд олон улсын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, дүнгийн албан ёсны тодорхойлолтыг үндэслэнэ.

3.7.5 А түвшний шалгалтын оноогоор дүйцүүлсэн бол ижил чиглэлийн AS түвшний шалгалтын оноогоор дүйцүүлэхгүй.

Уг шалгалтын оноогоор ОТИС-ийн ерөнхий суурьт тусгасан гүнзгийрүүлсэн түвшний хичээлийг дүйцүүлэхгүй.

**Дөрөв. Багц цаг шилжүүлэн тооцох аргачлал**

4.1 Багц цагийн тодорхойлолт нь ОТИС-тай ижлээр тодорхойлогдсон хичээлийн багц цагийг тэр хэвээр нь ашиглах бөгөөд багц цагийг өөрөөр тодорхойлсон бол нэмэлт тайлбар шаардана.

4.2 Гадаадын их, дээд сургуулиудад түгээмэл хэрэглэгддэг ялгаатай багц цагийг Хавсралтын Хүснэгт 1-т заасны дагуу шилжүүлэн тооцно.

4.3 Журмын 3.1.3-т заасан нөхцөлөөс бусдаар ОТИС-ийн дүйцэх хичээлийн багц цагт хүрэхгүй бол шилжүүлэн тооцохгүй. Нөхөж судална.

4.4 Суралцагчийн судалсан хэд хэдэн хичээлийн багц цаг болон агуулга, суралцахуйн үр дүн нь ОТИС-ийн харгалзах хичээлийн багц цаг, агуулга, суралцахуйн үр дүнгийн шаардлагыг хангаж байвал хичээлүүдийг нэгтгэн дүйцүүлж болно.

4.5 Суралцагчийн судалсан хичээл нь ОТИС-ийн хэд хэдэн хичээлийн агуулга, суралцахуйн үр дүн, багц цагийн шаардлагыг хангасан бол тэдгээрийг тус тусад нь дүйцүүлж болно.

**Тав. Суралцагчийн үнэлгээг дүйцүүлэх аргачлал**

5.1 Бусад дээд боловсролын сургалтын байгууллагад түгээмэл хэрэглэгддэг үнэлгээний системийг хүснэгт 2-т заасны дагуу ОТИС-д хөрвүүлэн тооцно.

5.2 Суралцагчийн үнэлгээ нь ОТИС-ийн дүнгийн шатлалаас ялгаатай бол албан ёсны тайлбар авах боломжгүй тохиолдолд амжилттай дүнг 60-95 онооны завсарт жигд харгалзуулан шилжүүлэн тооцно.

5.3 ОТИС-д дүйцүүлэн тооцох дүн нь ОТИС-ийн үнэлгээний системийн аль нэг интервалаар тодорхойлогдож байвал уг интервалын дундаж утгаар эцсийн үнэлгээг тогтооно.

5.4 Журмын 4.5.-т заасны дагуу нэг хичээлээр ОТИС-ийн хэд хэдэн хичээлийг дүйцүүлэх бол ОТИС-ийн хичээл бүрийн үнэлгээ нь дүйцүүлэх хичээлийн үнэлгээтэй ижил байна.

5.5 Олон улсын шалгалтын A үнэлгээг 95, B үнэлгээг 85, C үнэлгээг 75, AS түвшний A үнэлгээг 85 оноогоор тооцно.

**Зургаа. Хэлний шалгалтын оноог дүйцүүлэх**

6.1 Мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлийн бүлэгтээ гадаад хэл судлуулахаар тусгасан бакалаврын сургалтын хөтөлбөрийн анхан шатны хэлний хичээлүүдийг харгалзах хэлний олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын оноогоор дүйцүүлэн тооцож болох боловч шалгалтын оноо нь тухайн шалгалтаар авч болох хамгийн их онооны 60 хувиас багагүй байх тохиолдолд дүйцүүлэх боломж нээгдэнэ. Албан ёсны гэрчилгээг хавсаргана.

6.2 Дүйцүүлж болох олон улсын шалгалтын нэр, түвшин тогтоосон гэрчилгээний хүчинтэй хугацаа болон дүйцүүлж болох хичээлийн нэр багц цагийг мэргэжлийн тэнхим хэлэлцэж шийдвэрлэн дүнг сургалтын нэгдсэн албанд илгээнэ.

6.3 Гадаад хэлний шалгалтын гэрчилгээний оноогоор ОТИС-ийн ахисан түвшний хөтөлбөрийн хичээл дүйцүүлэхгүй.

6.4 Гадаад хэлний шалгалтын гэрчилгээгээр дүйцүүлсэн хичээлийн төлбөр нь нийт сургалтын төлбөрөөс хасагдахгүй.

**Долоо. Хичээл дүйцүүлэх үйл ажиллагаа**

7.1 ОТИС-ийн хичээл дүйцүүлэхийг сургалтын нэгдсэн алба дангаар эсхүл мэргэжлийн тэнхимтэй хамтран хэрэгжүүлнэ.

7.2 ОТИС-д дүйцүүлж буй хичээл нь журмын баримтлах зарчим болон харгалзах хичээлийн агуулгаараа давхцаж байгаа эсэх, багц цагийн хэмжээ нь шаардлага хангаж байгаа зэргийг бүтцийн сургуулийн захирлын баталгаажуулснаар эцэслэн удирдлагын мэдээллийн системд оруулна.

**Найм. Бусад**

8.1 Хичээл дүйцүүлэхийг суралцагч элссэн, шилжсэн, эргэн суралцсан тухайн улиралд нь суралцагчийн хүсэлтээр нэг удаа хийнэ.

8.2 Дүйцүүлэх аргачлалыг чанд баримтлах ба буруу хийсэн бол дахин засварлаж оруулна.

8.3 Оюутан солилцооны болон бусад гэрээнд тусгайлан заагаагүй бол ОТИС-д хичээл дүйцүүлэхэд төлбөр авахгүй.

8.4 Энэхүү журмаар зохицуулагдаагүй асуудал үүсвэл ОТИС-ийн ректорын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.